

“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМЫН ХӨГЖЛИЙН АСУУДЛУУД” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ БОЛЛОО

УИХ-ын даргын 119 дүгээр захирамжаар байгуулагдсан Дамжин өнгөрөх тээвэр, логистикийн бодлого тодорхойлох ажлын хэсэг, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, Их Британий Кэмбрижийн их сургууль, Монголын төмөр замын инженерүүдийн холбоо хамтран “Монголын төмөр замын хөгжлийн асуудлууд” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг 2013 оны 8 дугаар сарын 21-ний өдөр Төрийн ордонд зохион байгуулав.

Эрдэм шинжилгээний хуралд Улсын Их Хурал, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, шинжлэх ухааны байгууллагууд, мэргэжлийн холбоод, салбарын аж ахуйн нэгж зэрэг 30 гаруй байгууллагын 150 орчим төлөөлөгчид оролцлоо.

Энэхүү хурлаар Монгол Улсын төмөр замын тээврийн салбарын өнөөгийн байдал, хэрэгжүүлж буй төслүүд, цаашдын хөгжлийн чиг хандлага, дамжин өнгөрүүлэх тээврийг хөгжүүлэх асуудал, хөрш ОХУ, БНХАУ-ын төмөр замын хөгжлийн хандлага чиглэл, эдгээр улсуудаас Ази-Европыг холбон хэрэгжүүлж буй төмөр замын мега төслүүд, түүнд манай улсаас харилцан ашигтай оролцох боломжийн талаар олон чухал санал дэвшүүлсэн 10 гаруй илтгэл хэлэлцүүлж улс орны хөгжилд төмөр замын гүйцэтгэх үүргийг бодитой нэмэгдүүлэх, гадаад орнуудын туршлагаас судлах, нэвтрүүлэх, хамтран ажиллах талаар мэргэжлийн байгууллагын төлөөлөл, эрдэмтэн судлаачид санал бодлоо солилцлоо. Монгол улсад дамжин өнгөрүүлэх тээврийг хөгжүүлэх боломж, түүний ач холбогдлыг түлхүү анхаарч хэлэлцсэн юм.

Ази, Европыг холбосон төмөр замын хамгийн дөт замнал болох манай улсын хувьд цаашид газарзүйн байрлалынхаа давуу талаа ашиглан хөрш хоёр улс, Сибирийн бүсийг БНХАУ-ын аж үйлдвэрийн бүстэй холбох эдийн засгийн харилцааны гол гүүр болох бодлогыг тууштай баримтлах замаар тээврийн дэд бүтэц, нефть, хийн хоолой, холбооны болон эрчим хүчний сүлжээний томоохон төслүүдийг хэрэгжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эдийн засгийн шинэ бүсүүд бий болгох, байгаль орчинд ээлтэй эрчим хүчний шинэ эх үүсвэртэй болох, бүс нутагтаа тээврийн сүлжээний нэг гол зангилаа болж улс орныхоо эдийн засгийн өсөлтөд тодорхой хувь нэмэр оруулах асуудал чухлаар тавигдаж байна.

Цаг үеийн энэхүү бодит шаардлагыг хангаж, төмөр замын

Олон улс судлал

талаар төрөөс баримтлах бодлого чиглэлийг оновчтой болгоход ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгээс хамтран зохион байгуулсан “Монголын төмөр замын хөгжлийн асуудлууд” эрдэм шинжилгээний хурал зохих хувь нэмэр оруулсан чухал арга хэмжээ боллоо.

Мэдээ бэлтгэсэн Р.Төрдалай
/ОУСХ-гийн ЭША/